

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР****САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/138/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхнасан

Утас: 90066888

Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг

Утас/Факс: 7046-36-12

И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2024.03.14 № 234.
танай _____ -ны № _____ -т

ИДЭР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ш.САМПИЛНОРОВ-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Идэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Идэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 883,565.7 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 62,335.6 мянган төгрөгөөр, тус онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 348,121.9 мянган төгрөгөөр, татварын орлогын санхүүжилт 313,584.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн болон улсын төсөвт байгууллагын тогтмол зардал өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Идэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар Багийн Иргэдийн Нийтийн хуралдаан даргалагчийн урамшууллыг 720,000 төгрөгөөр илүү тооцоолон олгосон зөрчил байна.

01.0 0410



Бусад асуудлын хэсэг

Идэр сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 235,779.2 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл нь 294,494.7 мянган төгрөг буюу 24,9 хувиар давсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	319,672.0	407,736.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	82,154.5	120,815.7
33	АВЛАГА	218,920.8	263,835.2
35	БАРАА МАТЕРИАЛ	18,596.7	23,085.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	732,110.7	827,498.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	732,110.7	827,498.2
39200	Биет хөрөнгө	726,524.7	807,340.2
39300	Биет бус хөрөнгө	5,586.0	20,158.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,051,782.7	1,235,234.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,051,782.7	1,235,234.3
51	Засгийн газрын хувь оролцоо	1,051,782.7	1,235,234.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	696,313.9	696,313.9
51200	Хуримтлагдсан үр дүн	345,816.0	529,267.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,652.7	9,652.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,051,782.7	1,235,234.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,201,305.2	1,446,868.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	251,249.4	313,585.0
110	Орлогын албан татвар	139,021.7	169,631.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	159,840.1	195,017.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,818.4	-25,385.9
113	Хөрөнгийн албан татвар	53,237.5	52,264.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	58,990.2	91,688.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	153,160.6	191,728.9
120	Нийтлэг татварын бус орлого	153,160.6	191,728.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	796,895.3	941,554.7
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,007,947.0	993,487.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,007,947.0	993,487.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,276.6	954,560.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,150.0	412,640.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,711.7	51,614.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,322.5	24,263.2
2104	Хангамж, бараа материалын зардал	33,934.2	46,809.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,202.5	1,344.1
2107	Томилголт, зочны зардал	1,908.9	4,762.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,428.3	37,858.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,618.6	375,267.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	509,670.4	38,927.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	193,358.2	453,381.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,319,189.2	205,445.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,125,831.1	247,935.8



2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,322,171.9	3,322,171.9
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,051,782.7	1,051,782.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,177,613.8	3,177,613.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-144,558.2	-144,558.2
9	Тайлант үеийн үр дүн	-2,125,831.1	-2,125,831.1
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,051,782.7	1,051,782.7
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,235,234.3	1,235,234.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	987,298.6	987,298.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-64,484.1	-64,484.1
19	Тайлант үеийн үр дүн	247,935.8	247,935.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,107,890.9	1,319,781.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	251,249.4	313,585.0
110	Орлогын албан татвар	139,021.7	169,631.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	159,840.1	195,017.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-20,818.4	-25,385.9
113	Хөрөнгийн албан татвар	53,237.5	52,264.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	58,990.2	91,688.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,683.1	3,571.7
1181	Газрын төлбөр	1,393.4	22,548.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	55,913.7	65,568.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,746.2	64,642.1
120	Нийтлэг татварын бус орлого	59,746.2	64,642.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	796,895.3	941,554.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	921,549.3	897,192.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	921,549.3	897,192.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	411,579.9	858,265.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	252,150.0	412,640.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,711.7	51,614.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,060.4	24,263.2
2104	Хангамж, бараа материалын зардал	23,616.6	23,087.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,227.5	1,344.1
2107	Томилолт, зочны зардал	1,908.9	4,762.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,704.1	38,878.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,200.8	301,675.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	509,969.4	38,927.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	186,341.6	422,589.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	188,397.2	299,027.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	188,397.2	299,027.8
2200	Дотоод эх үүсвэрээр	188,397.2	299,027.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-188,397.2	-299,027.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-37,968.1	-84,900.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР	37,968.1	84,900.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-40,023.7	38,661.2



101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	122,178.1	82,154.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	82,154.5	120,815.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,256,178.3	1,198,077.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	846,221.3	825,104.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	832,619.1	817,984.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,257.8	412,640.3
210101	Үндсэн цалин	288,707.4	272,889.2
210102	Нэмэгдэл	119,866.7	122,216.3
210104	Урамшуулал	8,683.7	17,534.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,157.4	51,614.5
210201	Тэтгэврийн даатгал	35,466.9	35,097.8
210202	Тэтгэмжийн даатгал	4,172.5	4,129.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,338.2	3,303.5
210204	Ажилгүйдлийн даатгал	834.6	825.8
210205	Эрүүл мэндийн даатгал	8,345.2	8,258.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	270,430.2	264,134.6
210301	Гэрэл, цахилгаан	24,042.4	21,132.1
210302	Түлш, халаалт	243,195.6	242,743.6
210303	Цэвэр, бохир ус	3,192.2	258.9
2104	Хангамж, бараа материалын зардал	20,144.5	19,998.4
210401	Бичиг хэрэг	3,326.0	3,326.0
210402	Тээвэр, шатахуун	13,550.6	13,550.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,752.8	2,752.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	515.1	369.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,344.1	9,624.4
210604	Урсгал засвар	11,344.1	9,624.4
2107	Томилолт, зочны зардал	4,642.1	4,222.2
210702	Дотоод албан томилолт	4,642.1	4,222.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,159.6	5,270.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,200.0	4,311.0
210803	Даатгалын үйлчилгээ	469.1	469.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.7	227.7
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27.8	27.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.4	203.4
210807	Газрын төлбөр	31.6	31.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,483.4	50,480.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,680.0	49,680.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	803.4	800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,602.2	7,120.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,602.2	7,120.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,602.2	7,120.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	314,957.0	288,072.8
223001	Бусад хөрөнгө	314,957.0	288,072.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	95,000.0	84,900.0
230001	Эргэж төлөгдөх зээл	95,000.0	84,900.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,256,178.3	1,185,020.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,114,005.8	1,125,089.1
320001	Орон нутгийн төсвөөс	853,021.3	864,104.6
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	260,984.5	260,984.5



35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	142,172.5	59,931.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	59,931.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	142,172.5	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	59,228.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	46,171.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	72,127.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	72,127.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,235.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,153.4
210301	Гэрэл, цахилгаан	3,241.2
210302	Түлш, халаалт	912.2
2104	Хангамж, бараа материалын зардал	3,088.8
210401	Бичиг хэрэг	350.0
210402	Тээвэр, шатахуун	2,388.8
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	350.0
2107	Томилолт, зочны зардал	540.0
210702	Дотоод албан томилолт	540.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,608.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,608.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,845.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,845.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,892.1
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,892.1
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,892.1
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	72,127.9
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	72,127.9
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,127.9

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Идэр сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Төр засгийн бодлого шийдвэрийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулж, мэргэшсэн албан хаагчдаар төрийн албыг бэхжүүлэн, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэж, сумын хөгжлийн төлөө ажиллахад оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 93 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 80 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Идэр сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.



Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Идэр сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 183,451.7 мянган төгрөгөөр буюу 17.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	82,154.5	120,815.7	38,661.2
Авлага	218,920.8	263,835.2	44,914.4
Бараа материал	18,596.7	23,085.2	4,488.5
Үндсэн хөрөнгө	732,110.7	827,498.2	95,387.5
Нийт хөрөнгө	1,051,782.7	1,235,234.3	183,451.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,051,782.7	1,235,234.3	183,451.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,051,782.7	1,235,234.3	183,451.7

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 120,815.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 38,661.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь сумын ОНХС-ийн үлдэгдэл, төвлөрүүлэх шилжүүлэг өссөн нь гол нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	82,154.5	120,815.7	38,661.2
Дүн	82,154.5	120,815.7	38,661.2

Эх сурвалж: Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй



3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 263,835.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 44,914.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	74,917.5	82,627.6	7,710.1
Хувь хүмүүсээс авах авлага	144,003.3	181,207.6	37,204.3
Дүн	218,920.8	263,835.2	44,914.4

Эх сурвалж: Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 44,914.4 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага 37,204.3 мянган төгрөгөөр, сумын ОНХС-ийн байгууллагаас авах авлага 7,710.1 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 23,085.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,488.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	831.8	831.8	0.0
Тусгай зориулалттай материал	831.8	831.8	0.0
Хангамжийн материал	10,154.9	14,643.4	4,488.5
Бичиг хэргийн материал	846.0	1,173.8	327.8
Аж ахуйн материал	9,308.9	13,469.7	4,160.7
Мал амьтад	7,610.0	7,610.0	0.0
Дүн	18,596.7	23,085.2	4,488.5

Эх сурвалж: Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 4,488.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 58,748.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 54,256.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, аж ахуйн материал 4,160.7 мянган төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 827,498.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 95,387.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	<i>/мянган төгрөгөөр/</i>		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	-	-	-
Биет хөрөнгө	726,524.7	807,340.2	80,815.5
Барилга, байгууламж, орон сууц	591,952.2	665,952.2	74,000.0



Авто-тээврийн хэрэгсэл	176,554.8	238,694.8	62,140.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	230,993.4	243,702.9	12,709.5
Тавилга, аж ахуйн эд хогшил	31,889.8	22,629.7	-9,260.1
Бусад үндсэн хөрөнгө	155,685.4	155,685.4	0.0
Ном	1,017.0	1,017.0	0.0
Биет бус хөрөнгө	5,586.0	20,158.0	14,572.0
Программ хангамж	4,372.0	4,372.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	3,996.0	19,198.0	15,202.0
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(464,349.9)	(523,753.8)	(59,403.9)
Дүн	732,110.7	827,498.2	95,387.5

Эх сурвалж: Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 95,387.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10,955.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, 151,342.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө үнэ төлбөргүйгээр, хандиваар 21,171.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн, 28,677.5 мянган төгрөгийн хөрөнгө шийдвэрийн дагуу акталсан, тайлант оны элэгдлийн зардалд 88,081.4 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,235,234.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 183,451.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	696,313.9	696,313.9	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	696,313.9	696,313.9	0.0
Хуримтлагдсан үр дүн	345,816.1	529,267.7	183,451.7
Өмнөх үеийн үр дүн	2,471,647.1	281,331.9	(2,190,315.2)
Тайлант үеийн үр дүн	-2,125,831.1	247,935.8	2,373,766.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,652.7	9,652.7	0.0
Дүн	1,051,782.7	1,235,234.3	183,451.7

Эх сурвалж: Идэр сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 183,451.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.


3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,073,213.5 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 827,506.8 мянган төгрөг байна.



3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн ... арга хэмжээг санхүүжүүлэхээр 263,137.8 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 210,024.5 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал 245,706.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 227,172.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 127,172.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 86,984.1 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 50,960.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 07 сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 1,256,178.3 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 348,121.9 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 260,984.5 мянган төгрөгийн, улсын төсөвт байгууллагын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 260,320.4 мянган төгрөгийн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 59,931.5 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 255,579.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 83.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 71,157.7 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 2,000.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, сумын ИТХ-д санхүүжилт дутуу олгосон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	350,121.90	348,121.90	2,000.0
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	260,984.50	260,984.50	0.0
3	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	260,320.40	260,320.40	0.0
4	Татварын болон татварын бус орлого	255,579.00	255,579.00	0.0
5	Урьд оны үлдэгдэл	129,172.50	83.30	
6	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	59,931.50	59,931.5
ДҮН		1,256,178.3	1,185,020.6	71,157.7

Татварын болон татварын бус орлогоор 343,681.5 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 25,385.9 мянган төгрөгийг, санхүүжилтэд 255,579.0 мянган төгрөгийг олгож, давж биелсэн 62,716.6 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,198,077.4 мянган төгрөг буюу 95.4 хувьтай байгаа нь сумын ИТХ-ын БИНХ-ын урамшууллыг хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	103,060.6	90,268.9	12,791.7	87.6%
2	Засаг даргын Тамгын газар	482,840.3	482,530.5	309.8	99.9%
3	Орон нутгийн хөгжлийн сан	314,957.0	288,072.8	26,884.2	91.5%
4	Хоршоо хөгжүүлэх сан	95,000.0	84,900.0	10,100.0	89.4%
5	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	260,320.4	252,305.2	8,015.20	96.9%
ДҮН		1,409,970.2	1,256,178.3	1,198,077.4	95.4%

Батлагдсан төсөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.



Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 72,127.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 51,235.8 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 20,892.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Идэр сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Идэр сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 1/62 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 2,084,871.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 31,273.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 23,454.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 9 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.


4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг





Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн	
Дүн													

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Б.МӨНХНАСАН

Огноо: 2024-03-25

